


ТӨМС

Ач холбогдол.



В,С амин дэм хялбар шингэх эрдэс бодис, цардуул ихээр агуулдаг.

Сорт. Манай орны хөрс цаг уурын нөхцөлд эрт ба дундын болцтой Лорх, Астелла, Приекульский ранний зэрэг сортуудыг тариалах нь тохиромжтой. Приекульский ранний сорт нь махлаг цагаан эдтэй, амтлаг 65-70 хоногт болц нь гүйцдэг. Астелла сортын махлаг эд нь шар өнгөтэй ургах хугацаа нь 80-90 хоног

Ургах нөхцөл.



5°-9°С ийн дулаанд эрчимтэй соёолж 10°-20° С-д хөрсөн дор булцуу үүсэж, 18°-25°С-д цэцэглэлт явагдана. Хэт халуунд ургалт нь зогсдог учир хэт халуун болбол сэрүүцүүлэх усалгаа хийнэ.

Хөрс боловсруулалт. Элсэнцэр, хөнгөн шавранцар бүтэцтэй хөрсийг намар бүрэн ялзарсан бууцаар бордож 22-25 см гүн хагалж өвөлжүүлээд хавар нь 40-50 см гүнд нэвчитэл услаад 25-30 см гүнд хавж боловсруулна.

Үрийг бэлтгэх. 50-80 г жинтэй өвчилж муудаагүй, цэвэр булцууг сонгон авч агаар салхи сайн ордог гэрэлтэй байранд эсвэл гадаа наранд ээвэр нөмөр газар дэлгэж 25-30 хоног эртжүүлнэ. Эртжүүлэх гэдэг нь шөнөд нь сүрэл болон дулаан материалаар хучиж өдөрт нь хучилгыг авч бага зэрэг чийглэн наранд ээх байдлаар соёолуулах арга юм. Төмсний үрийг эртжүүлсэнээр тариалах явцад хугарахааргүй бахим бүдүүн ногоон соёо ургана. Ингэж эртжүүлсэн үрээр тарьсан төмсний болц 14-21 хоногийн өмнө гүйцдэг.

Тарилт.

Говийн нөхцөлд төмсийг 4-р сарын сүүлчээс 5-р сарын 10- ны хооронд тариална. Харин тарихын өмнө хөрсийг 40-50 см гүнд нэвчтэл усалсан байх хэрэгтэй.



Тарих үрийн хэмжээ, хөрсний чийгийн байдлаас тарих гүн хамаарна	Тарьц ба үрийн хэмжээ /гр/	Мөр хооронд /см/	Ургамал хооронд /см/	10м.кв талбайд орох үрийн хэмжээ /кг/
	Хальсаар	50-60	15-20	0,6-0,7
	50-80	60-70	25-30	2,5-3

Ээлжлэн тариалалт.



Арчилгаа.

Усалгаа ба маналт нь хамгийн чухал арчилгаа юм. Төмсгийг ургалтын хугацаанд нь 1 ам метрт 40-50л ус орохоор тооцоолж 3-4 удаа услана.

	Үрийг суулгасанаас 30-45 хоногийн дараа шинэ булцуу үүсгэх үндэс үүсэж эхлэдэг. Энэ үед төмсний навч 18-20 см өндөр ургасан байдаг. Яг энэ үед 1-р маналтыг хийнэ. 1-р маналт хийснээр хог ургамал бүрэн устана. Мөн нэмэлт үндэс бий болж тэр хэмжээгээр илүү олон булцуу үүснэ. Маналтын өмнө хөрсний чийг хангалтгүй бол заавал усалгаа хийнэ. Ер нь маналт нь төмсний гол арчилгаа бөгөөд төмсгийг манах явцад хөрс сийрүүлэх, зэрлэг устгах ажлууд хамтдаа хийгдэнэ.
	1-р маналтаас хойш 14 хоноод ишний өндрийн гуравны хоёрыг далд ортол манана. Үүнийг 2-р маналт гэнэ. Энэ үед цэцгийн бундуу үүсэж эхэлж байдаг. Төмсний цэцгийн бундуу үүсэх үетэй зэрэгцэн хөрсөн доорхи төмс томорч эхэлдэг тул наранд ил гарч ногоордог. Энэ нь төмсөнд салонин гэдэг бодис үүсч байгаа хэлбэр. Үүнээс урьдчилан сэргийлэх, намрын эхний хүйтрэлтийн үед төмс хөлдөхөөс хамгаалах, булцууг торуулах зорилгоор 2-р маналтыг заавал хийнэ.

Өвчин, хортон түүнтэй тэмцэх.

Өвчин. Фитофоторын үед бутны доод талын навчны өнгөн талд дугуй хэлбэрэй хүрэн толбо гарч ирнэ. Энэ нь төмсний бүх эрхтэнг өвчлүүлэх ба хур бороо ихтэй үед илүү их тархана. Энэ өвчнөөр өвчилсөн төмсний булцуунд, ургац хурааснаас хойш 2-3 долоо хоногийн дараа өвчний шинж тэмдэг илэрнэ. Энэ үед булцууны гадаргууд хонхойсон хүрэн толбо үүсч зөөлөн эдийг өвчлүүлнэ. Төмсний өвчинтэй тэмцэхийн тулд цэвэр үрээр тарих ба нэг үрийг 3-аас дээш жил давтан тарихгүй байх, тарих үрийг ариутгах зэрэг арга хэмжээ авна

Хортон. Төмсгийг улаан толгойтой далавчин дээрээ цагаан судалтай хар жант цох, улаан өнгийн далавчтай судалт жант цох ихээр хөнөөдөг.

Эдгээр шавьжтай тэмцэхийн тулд детис, хлорфос зэргийг 10литр усанд 30 г-аар найруулан цацна. Мөн талбайгаа тойруулан шар хуйс зэрэг цохын идэх дуртай тарималыг тарьж талбайд орохоос урдчилан сэргийлнэ.

Энэ үед хортон тэр таримал дээр цугларч хөгжлийн үеэ өнгөрүүлээд үхдэг.

Хураалт. 1 м.кв талбайгаас 4кг ургац авна. Төмсний иш хагдрахгүй бол хураахаас 14-21 хоногийн өмнө ишийг хадах, зориудаар хагдруулах арга хэмжээ авна. Энэ нь төмсний хальсжилтыг сайжруулж хадгалалт даах чадварыг нэмэгдүүлнэ.